



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/60

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Номингийн уулзвараас Очир төв хүртэлх авто замын дагуух талбайн тохижилт ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
Гишүүдэд:	Р.Алимаа	- 3 дугаар сургуулийн багш
	Н.Чинзоригт	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Ц.Нямбаяр	- Иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	Д.Дариймаа	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 0345  
D:\tush-A\60-Bo